

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
04 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-12
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-122
	1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл <i>/Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	15-68
	2.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 14 гишүүн 2022.03.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	69-103
	3.Гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төсөл <i>/Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	103-110
	4.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 4 гишүүн 2020.01.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	110-122

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.Энхжин, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор, Э.Батшугар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа хариулж, тайлбар хийв.

Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Гурав.Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дэд дарга, Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хорооны дарга Хүрэлбаатарын Булгантуяа танилцуулна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн байгаа. Тус байнгын хорооны 2022 оны 4 дүгээр сарын арван дөрөвний өдрийн хуралдаанаар гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцсэн болно.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл нар асуулт асуусан бөгөөд чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан санал, 30 гаруй иргэдээс Ди парламент аппликэйшнээр ирүүлсэн саналуудыг ажлын хэсгийн түвшинд хэлэлцсэн талаар Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Х.Булгантуяа танилцууллаа.

Чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн эцсийн хувилбарын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хууль, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух, Улсын Их Хурлын гишүүн байна уу? Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Мэдээж энэ асуудлыг цаг алдалгүй шуурхай шийдэх ёстой гэдэг дээр бараг бүх гишүүн санал нэгтэй байгаа. Тэгээд бид нар энэ дээрээ яг шийдэхдээ зохион байгуулалт тал дээр маш сайн анхаарч Улсын Их Хурлаас энэ хуулийн төслийг гаргахдаа бас тодорхой зааж өгөх шаардлага байгаа юм. Бид нар 2012-2014 оны хооронд Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн яг яаж явагдсан хүндээ хүрсэн үү, энэ хөтөлбөрийн үр дүн үнэхээр зах зээл дээр тухайн аж ахуйн нэгжүүд дээр үнэ ханш дээр гарсан уу гэдгийг Монголбанкн дээр шалгах ажлын хэсгийн нэг гишүүнээр би ороод шалгахад байсан л даа. 4 орчим их наяд төгрөг яг энэ үнэ тогтворжуулахтай холбоотой гарсан. Тэгэхдээ яг сайн зохион байгуулалт яг эзэндээ очиж чадаагүй учраас үр дүн нэг их сайн өгөөгүй. Харин энэ нэрэн дор асар их хөрөнгө мөнгө гарч явсан л даа. Бараг салхинд хийсэн зарим нь гэж хэлж болно. Тэгэхээр бид нар өнөөдөр мах, гурил, бензин шатахуун тухай ярьж байгаа. Ялангуяа нефть бүтээгдэхүүний үнэ ханшийг бол тогтворжуулах тэр илүүтэй энэ ойрын хугацаанд бол үр дүнгээ өгөх байх гэж бид харж байна. Харин мах, гурил дээр бол ирэх жил илүү их нөөц хуримтлуулах, бас ингээд хөл алдчихгүй байх дээр бид бэлэн байх үүднээс ингээд урьдчилан сэргийлэх арга хэмжээг бас авч байгаа нь харагдаж байна л даа.

Ер нь мэдээж үнэ ханш бол зөвхөн манай улсад ингэж өсөөгүй. Өчигдөр НҮБ-аас гаргадаг дэлхийн хүнсний үнийн индексээс харахад 1990 оноос хойш хамгийн өндөр түвшиндээ хүрсэн үзүүлэлтүүд гарсан байгаа. Гэхдээ харамсалтай нь Азийн орон дотроо манай Монгол Улс хамгийн өндөр буюу 14.6 хувийн инфляцтай байгаад байгаа юм. Энэний хамгийн гол шалтгаан нь гэхээр бид дотооддоо юу ч бараг үйлдвэрлэхгүй байгаатай холбоотой байна л даа. Бүх юмаа гаднаас авдаг. Тэр битгий хэл дотоод дотооддоо үйлдвэрлэж байна гээд жишээлбэл эмийн үйлдвэр ч гэдэг юм уу, бусад сав баглааны үйлдвэр байгаа хэрнээ бүх тэр нарийн юмнуудаа дандаа урд улсаас оруулж ирдэг.

Тэгээд өнөөдөр хил хаасан чинь нөгөө үндэсний гэх үйлдвэрүүд маань ихэнх нь үүдээ барьчихсан, эсвэл түүхий эдгүй болчихсон ийм байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар нэг ажлыг хийхдээ яг л зориулалтаар, дотооддоо үйлдвэрлэнэ гэсэн бол дотооддоо үйлдвэрлэдэг, үнэ тогтворжуулах юм уу, үнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авъя гэвэл яг тэр мах бэлтгэх гэж байгаа хүмүүст мөн гурил үйлдвэрлэгчдэд юм уу, эсвэл нефть бүтээгдэхүүн хийж байгаа хүмүүс яг юун дээр нь, хаана нь шалтгаан байгаад байна гэдгийг нь олоод, тэр шалтгааныг нь бид зохицуулах арга хэмжээг л авахын тулд өнөөдөр Улсын Их Хурал Засгийн газраас оруулж ирж байгаа энэ хуулийн төслийг хэлэлцэж байгаа гэж би бодож байгаа.

Тийм учраас би бас Улсын Их Хурлын даргын зүгээс, ер нь өнөөдөр манай гишүүд маань ч гэсэн энэ хуулийн заалт болгон дээр багахан л хэмжээний заалт шүү дээ. Тэр зохион байгуулалт, эргээд бид энийг хариуцлага тооцох, эсвэл хяналтын механизмыг нь хүртэл тодорхой зааж өгөөд эргээд үр дүнг нь хэмжихдээ бид яг ингэж тусгаж өгсөн, зориулалт нь ийм байсан, үр дүн нь тэр хугацааны дараа ингэж гарна гэдгийг маш сайн тусгаж өгөх ёстой шүү гэдгийг би хэлэхийг хүсэж байгаа юм.

Энэ бол санал гэж хэлж болно. Энэ Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундетагийн гишүүдтэй өчигдөр манай Сарангэрэл гишүүн бид нар уулзсан. Герман улс төсвөө жилд хоёр удаа хагас жилээр хийдэг юм байна. Манайх шиг бүтэн жилээр нь биш. Тэгээд 7 сарын 1-нд яг тэтгэвэр, цалинтай дандаа тохиргоо хийдэг. Тохиргоо

хийхдээ улс төрийн нөлөөлөлгүй зөвхөн статистик, тэр индексжүүлсэн байдал дээрээ яг автоматаар бүх юм нь гарч ирээд л тооцоо судалгаануудаа хийгээд, тэгээд хагас жилээр төсвөө хэлэлцээд явчихдаг учраас өнөөдөр энэ улс 2008 он, 2009 оны эдийн засгийн хямралд өртөөгүй. Өнөөдөр ч гэсэн КОВИД-ын нөхцөл байдлын үед жишээ нь тэтгэврээ огцом нэмэх нөхцөл бололцоо бүрдэж байгаа гээд өчигдөр ярьж байна лээ л даа. Тэгэхээр бид нар ч гэсэн цаашдаа төсөв хэлэлцэх үедээ ч гэсэн маш ингэж нэлээд няхуур хандаж байх ёстой шүү гэдгийг бас хэлмээр санагдсан.

Бид ингээд л байсхийж байгаад төсвөө тодотгоод ороод ирдэг. Тэгээд дахиад л бүх юмаа эхнээс нь ингээд хөдлөхөд хүрдэг. Энэ нь эргээд асар их ажил, цаг хугацаа, хөрөнгө мөнгө үрдэг. Тэгэхээр энэ байдлыг бас ер нь цаашдаа халах ёстой юм байна гэсэн бодолтой байгаагаа хэлье гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал юм даа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би товчхон зүйл хэлье. Энэ чинь асууж болох л зүгээр үг хэлэх билүү.

Г.Занданшатар: Асуулт шүү дээ. Байнгын хорооны танилцуулгаас.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хорооноос би асуух гээд байгаа юм. Өмнө нэг зүйл хэлэхэд бид нар 2012-2016 онд Үнэ тогтворжуулах хөтөлбөр гэж хэрэгжүүлсэн шүү дээ. Тэгэхээр тэр үнэ тогтворжуулах хөтөлбөрийн гаргасан алдаа завхралыг л бид давтаж болохгүй учиртай юм л даа. Тийм учраас бол энэ хэлэлцүүлгийн явцад гишүүд бид нар нэлээн сайн хэлсэн. Энэ ажлын хэсэг бол сайн шат шатандаа энийг засаад одоо ийм алдаа гарахааргүйгээр оруулж ирсэн гэж ингэж ойлгож байгаа. Монголбанкнаас шууд мөнгө хэвлэж нийлүүлэх ийм алдаа дутагдлыг бол гаргахааргүйгээр оруулж ирсэн гэж би ингэж ойлгож байгаа. Энэ бол их сайн үзүүлэлт.

Нөгөө талынх нь юм бол би өмнө нь асуух гээд асууж чадаагүй хоёр зүйл байгаа юм. Бид нар одоо ингээд махны үнийг тогтвортой барина, гурилын үнийг тогтвортой барина гээд. Ингээд мах бэлтгэн нийлүүлдэг компаниуд руугаа, гурил үйлдвэрлэгч компаниуд руугаа л боломж олгох гээд байгаа ийм асуудал шүү дээ. Тэгэхээр би удаа дараа хэлээд байгаа юм бол яг анхан шатанд нь үйлдвэрлэгч, баялаг бүтээгч тэр хүмүүс рүүгээ, тухайлбал малчид руугаа хандсан ямар бодлого байх вэ. Нөгөө талынх нь юм бол үр тариа үйлдвэрлэж байгаа энэ үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд, хувь хүн, газар тариалан эхэлж байгаа хүмүүс рүүгээ ямар дэмжлэг байх юм бэ? Энийг тодорхой болгооч гэж удаа дараа ийм асуудлыг тавьсан. Тэгэхээр энэ дээр Байнгын хороон дээр юу гэж үзсэн юм бэ? Энэ хуулийн төсөлд тодорхой, Улсын Их Хурлын гишүүд Туваан гишүүн байна, хэд хэдэн гишүүн бид нар нэг байр суурьтай л ийм асуудлуудыг тавьж байсан л даа. Энэ дээр нэг хариулт авмаар байна. Хүнсний ногоо, ялгаа байхгүй. Хүнсний ногоотой холбоотой, цаашлах юм бол өвлийн хүлэмжтэй холбоотой.

Энэ КОВИД-ын цар тахлын үед чинь хил хаалттай үед салатны байцаа нэг килограмм нь 25000 төгрөг хүрлээ шүү дээ. Бид нар ийм арчаагүй сууж байж таарахгүй байх гэж ингэж л үзээд байгаа юм л даа. Нарийн ногооны хэрэглээ ихэнхдээ төв суурин газрын, төв суурин газартаа ресторан, хоолны газар, үйлчилгээний газруудад л хэрэглэнэ шүү дээ. Тэгтэл бид нар дандаа гаднаас дээвэр туургаар энийгээ авдаг. Энэ өвлийн хүлэмжийг хөгжүүлэхтэй холбоотой энэ хүндрэл бэрхшээл бол нөгөө талдаа бидэнд боломж нээж өгдөг учраас энэ асуудлыг цогцоор нь авч үзсэн ийм зүйлүүд байгаа юу? Энэнтэй холбоотой асуудал яригдсан. Энэ бас

тодорхой хэмжээнд тусгалаа олсон байх гэж ингэж бодож байгаа. Миний асуусан түрүүний хоёр асуултад хариулт өгөөч. Баярлалаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултад хариулъя.

Х.Булгантуяа: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд энэ урамшуулал бол намар 8 сараас ерөнхийдөө эхлэх юм байна. Гурил, мах худалдан авалт авдаг гол бизнесүүдэд санхүүгийн эх үүсвэрийг бий болгоход зарцуулагдана. Одоо харин хавар тариалан эрхлэлт, малчдад арьс шир, ноос ноолуур, газар тариалангийн хувьд 10 их наядын цогц төлөвлөгөөний хүрээнд энэ санхүүжүүлэгдээд дэмжигдээд бас явж байгаа. Төсөв дээр бас тодорхой хэмжээний урамшууллууд тавигдаад явж байгаа. Зөвхөн 10 их наядын хүрээнд гэхэд газар тариалангийн үйлдвэрлэл хаврын тариалалтад нийтдээ 629 зээлдэгч хамрагдаад 2021 онд гэхэд 43.3 тэрбум төгрөгийн зээллэг авсан байна.

Малчдыг дэмжих гэдэг дээр 20000 орчим зээлдэгч хамрагдсан. Нийтдээ 200 орчим тэрбум төгрөг гарсан гэдэг ийм тоон мэдээллүүдийг Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас өгсөн юм. Энэ бол ерөнхийдөө яг нөөц бүрдүүлэлттэй холбоотой. Гэхдээ Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа үнэн л дээ. Энэ хавар хэрвээ газар тариалан яг энэ хаврын тариалалтыг дэмжихгүй бол энэ хавар онд өнөтэй ороод хавар мал төллөлтийн үеэр бас малчдаа дэмжихгүй бол намар бид нар юугаа хурааж авах вэ? Яаж махаа нөөцлөх вэ? Түүн дээр нь бол энэ 10 их наядын, дээрээс нь нэмээд жил болгон төсөв дээр тавьж явдаг малчдын, газар тариаланчдыг дэмжих санхүүгийн дэмжлэгүүд маань дэмжээд явчхаж байгаа.

Харин намар тийшээ болохоор яг мах нөөцлөх бид нар хэдхэн сарын хугацаанд махаа нөөцлөх хэрэгтэй болдог. Гурилын үйлдвэрүүд будаануудаа худалдаж авах хэрэгтэй болдог. Гурил будаа, мах нөөцлөх хангалттай хэмжээний мөнгийг бид нар тавиад дэмжээд өгчхөж байгаа юм байна гэвэл малчид маань ч гэсэн илүү дуртайгаар, илүү итгэл үнэмшилтэйгээр, газар тариалан эрхлэгчид маань ч гэсэн илүү их итгэл үнэмшилтэйгээр газар тариалан эрхлэхэд дэмжлэг болох юм гэж үзэж оруулж ирсэн юм байна лээ.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор.

Д.Өнөрболор: Энэ хуулийн хувьд дэмжиж байгаа юм. Хууль маань бол богино хугацааны шокийг тайлах, болзошгүй эрсдэлээс хохирол багатай гарах зэрэг арга хэмжээнүүд байгаа учраас ер нь бол дэмжиж байна. Гэхдээ энэ суурь өөрчлөлт, бодлогын өөрчлөлтийг бид нар зайлшгүй хийх ёстой гэж бодож байна. Энэ цар тахал, дайны нөлөөллөөс гэдэг энэ гадаад шалтгааныг бид нэрлэхээс гадна энэ суурь шалтгааныг дотоод шалтгаантайгаа холбож харах нь бас их зөв байна гэж бодож байна. Инфляцын нийт тоон дүнгийн хойноос бид нар хөөцөлдөх гэхээсээ илүү статистикийн тоо баримтаас харах юм инфляцын 50.9 хувийг импортын барааны өсөлт эзэлж байгаа гэдэг нь үнэхээр гол онош нь байгаад байгаа юм. Тиймээс бид хил гаалийн энэ гацаа хүндрэлээ хаана байгааг шийд гэсэн үг. Импортын урсгалыг саадгүй болго гэсэн үг. Дээрээс нь импортын хэрэгцээгээ өөрсдөө хангадаг болоход бодлогоо чиглүүлье гэсэн үг. Тэгэхээр Ерөнхий сайд гэхээсээ илүү энэ салбарын сайд нар, тэр дундаа энэ бодлогын яамдыг тэргүүлж байгаа сайд нар маань илүү сайн ажлаа хий гэсэн үг юм.

Өнөөгийн энэ хямралт нөхцөл байдалд олон шалтгаан бий л дээ. Гэхдээ тэр дотроо өнөөдөр бид сүүлийн 30 гаруй жил өрхийн үйлдвэрлэлээс үндэсний үйлдвэрлэл, үндэсний баялаг бүтээгчид хүртэлх энэ аж ахуйн харилцаагаа дэмжээгүйтэй холбоотой. Үндэсний үйлдвэрлэл, өрхийн аж ахуйг дэмждэггүй улс, төр

засаг бол өнөөдөр өрийн хавх, валютын ханшийн дарамт, импортын хараат байдал, инфляц, үнийн өсөлт зэрэг ийм хүндрэлээс гарах боломжгүйг бид нар ойлгох ёстой.

Улс орны эдийн засаг өнөөдөр давхар ийм хүнд нөхцөлд байгаа бодит байдалтай болоод бид нар нүүр тулгарч, үнэхээр эвлэрч энэ алдаагаа засах хэрэгтэй. Суурь өөрчлөх бодлогын өөрчлөлт хийхгүй бол ийм түр зуурын өнгөц заслаар хол явахгүй гэж хэлмээр байна. Энэ болгон нь гадааддаа ч тэр, дотооддоо ч тэр өнөөдөр гол асуудал нь Монгол Улс Худалдааны хуультай болох асуудал байсан. Сая энийг Эдийн засгийн байнгын хороон дээр ч гэсэн ярьж байна лээ. Миний би Улсын Их Хурлаас энэ Худалдааны хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг ахалж ажиллаж байгаа. Энэ хууль гурван ч удаа Улсын Их Хурлыг дамжсаар батлагдах нь битгий хэл бараг хэлэлцэгдээгүй, унаж унагаж ирсэн ийм түүхтэй хууль юм байна лээ.

Тэгээд эцсийн эцэст сүүлд сүүлдээ энэ хууль, эрх зүйн шинэчлэлтэй холбоотойгоор, энэ шинэ бүтэцтэй холбоотойгоор Хөрөнгө оруулалтын хуулийн төслөөр дамжуулаад миний нэр хүндэд халдах, тэр байтугай үндэсний дайсан мэт болгох ийм оролдлогыг холбож хийсэн. Тэгэхээр хийе, бүтээе гэсэн нэгнээгээ бас ингэж хорлож болохгүй ээ. Өнөөдөр улс орны эдийн засаг, эрх ашгийн өмнө бид нар өнөөдөр сахилга баттай, зөв хандлагатай, хариуцлагатай байх ёстой гэж бодож байна. Улсаа хөгжүүлэх, энэ эдийн засгаа тэлэх хүндрэлийг даван туулах гол арга хэрэгсэл үнэхээр яалт ч үгүй энэ Монгол Улсад Худалдааны хуультай болох асуудал байгаа юм. Энэ дээр манай гишүүд үнэхээр анхаарлаа хандуулж дэмжиж өгөөч гэж та бүгдээс хүсье.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, ажлын хэсэг асуултад хариулъя.

Х.Булгантуяа: Үнэн, энэ хуулийг хэлэлцэх явцад бас иргэд олон нийтээс ч гэсэн өмнөх Үнэ тогтворжуулах хөтөлбөрөөс юугаараа ялгаатай юм, байнгын ийм байдалтай байх юм шиг бас нэлээн шүүмжлээд ирсэн байна лээ. Гэхдээ өнөөдрийн энэ КОВИД бол олон салбарын алдаа дутагдлуудыг юу нь болохгүй байгаа, юу нь болж байгааг бас их харуулж байна гэж бодож байгаа. Хүнс, хөдөө аж ахуйн салбарт бид нар өөрсдөө үйлдвэрлэгч улс биш байсан. Өнөөдрийг болтол бид нар улсын төсвөөс маш их дэмжлэг олгож байсан ч гэсэн дэмжлэгээс дэмжлэгийн хооронд явж байсан болохоос биш биеэ даагаад өөрөө өөрийгөө өнөөдрийг болтол бас аваад явах ийм хүчтэй салбар болж хөгжиж бас чадсангүй.

Хил нь хаагдахад бид нар өнөөдөр сүүгээ ч гэсэн яаж хайрцаглах вэ гээд сандраад явж байгаа ийм улс орон бас болсон байна. Тийм учраас үүн дээрээ нэг удаа бид нар өнөөдөр энэ оныг дуустал энэ хуулийг баталж байгаа. Энэ нь ерөөсөө юмыг яаж мэдэх вэ, энэ дайн байлдааны хүнд нөхцөлд монголчууд бидний хамгийн өргөн хэрэглээ болсон инфляцад хамгийн хүчтэй нөлөөлж байгаа энэ гурван бараа бүтээгдэхүүнийхээ үнийг л бид нар тогтворжуулах, хангалттай нөөцийг нь бий болгох, ирэх өвлийг энэ намрыг бид нар ажил хэрэгч байдлаар нөөцөө бүрдүүлэх ийм л ажлыг зохион байгуулах гэж байгаа юм. Тэгэхдээ энэ холбогдох хуулиудыг, энэ төлөвлөгөөнүүдийг би холбогдох Байнгын хороод нь сонсоод бас явах ёстой гэж үзэж байгаа юм.

Тэгээд иргэд, олон нийтийн зүгээс ялангуяа улс эх орныхоо хүнс, хөдөө аж ахуйн салбарыг жижиг дунд бизнесийг бүр дэмжих цогц төлөвлөгөөг бид нар үүнийг дагуулаад гарах ёстой юм байна. Бас худалдааны том хуультай болох ёстой юм байна гэдэг энэ бүх санал санаачилгыг бол дэмжиж байгаа.

Г.Занданшатар: Энхбаярын Батшугар гишүүн асуулт асууна.

Э.Батшугар: Ер нь хүнсний үнийн өсөлт заавал Монголын биш бүх дэлхийн асуудал болчихсон байгаа юм. Ялангуяа энэ геополитикийн хүнд нөхцөлтэй холбоотойгоор. Орос, Украин хоёр нийлээд нийт хүнсний 12 хувийг нь хангадаг юм байна дэлхийн. Тэгээд сая 3 сард НҮБ-ын хүнсний үнийн индексийг харахад 12.6 хувиар өсчихсөн байна. Бусад улс орнуудын инфляцыг харахад бас өндөр өссөн. Жишээлбэл Турк улсын үнийн өсөлт нь бол 61 хувьд хүрсэн, Америкийнх 41 жилд байгаагүй өндөр түвшинд 8.5 хувьд хүрсэн. Мөн Хятад улсын үйлдвэрлэлийн инфляц нь бол 8.3 хувьд хүрсэн. Тэгэхээр юу харагдаж байна гэхээр ерөөсөө дэлхий дахин ийм үнийн өсөлт гэсэн тийм том проблемуудад нүүрлэлээ. Тэгэхдээ ганцхан яг өнөөдрийн байдлаар ганц Монгол Улс ийм хууль баталж байгаа шүү. Тэрийг бас онцлох нь зүйтэй гэж бодож байна.

Бусад улс орнуудад бол Төв банк болон Засгийн газар, Их Хурал нь хамтраад ийм хууль баталчихсан жишээ өнөөдрийн байдлаар байхгүй байгаа. Яах вэ, тус тусдаа бодлого хэрэгжүүлж байгаа. Жишээлбэл Америкийн улсын Төв банк нь дөрвөн жилдээ анх удаа өөрийнхөө бодлогын хүүгээ өсгөсөн, мөн бусад улс орнууд. Үүнтэй холбоотой бас Жозеф... гэдэг нэртэй Нобелийн шагналтай эдийн засагч энэ 2 сард нэг судалгаа хийж үг хэлсэн байдаг юм. Нийлүүлэлтийн гаралтай инфляци өнөөдрийн нөхцөл байдалд эрэлтийг нь болиулж үнэнд барина гэж байхгүй, харин нийлүүлэлтээр нь анхаарах ёстой гээд. Тэгээд өнөөдөр бид нар яг энийг л хийж байна л даа бас.

Асуулт байгаа юм. Энэ асуулт нь бас энэ хуультай холбоотой асуулт юу вэ гэвэл Оюу толгой 2021 онд ойролцоогоор 2 тэрбум долларын борлуулалт хийсэн, баяжмалаар. Энэний 750 сая доллар нь алт юм, 750 сая доллар. Энэ бол бараг нөгөө Монголбанкны ноднин худалдаж авсан 20 тонн алттай тэнцүү. Тэгэхээр энэ хуулийг ашиглаад одоо явж байгаа баяжмал нь Хятадад очоод боловсруулах үйлдвэрт очиж байгаа. Тэгэхээр яг энэ алтыг нь мөнгөжүүлсэн алт болгоод Монголбанкны дансанд Лондон ч юм уу, байршуулаад Монголбанк төгрөгөөр энд Оюу толгойд худалдаж авах бололцоо байгаа юу?

Мөн үүнтэй холбогдоод 5 хувийн премиум нь эдлээд бас нөгөө нэг хуулийн дагуу татвараас нь бас тодорхой хэмжээний нөгөө 5 хувьтай холбоотой чөлөөлчих, ингэснээр бид нар чинь бас алт худалдаад худалдан авалтаа 20 тоннд биш 40 тонн болгоод мөн ахиад 800 сая долларын илүү гадаад валютын нөөц бүрдүүлэх бололцоо байж магадгүй гэж л хараад байна л даа. Үүнд Монголбанкны талаас ямар нэгэн хариулт байгаа юу, тайлбар? Баярлалаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн ажлын хэсгийн ахлагч, Эдийн засгийн байнгын хороо асуултад хариулна.

Х.Булгантуяа: Батшугар гишүүн маш зөв асуудал бас хөндлөө. Энэ хуулийн 5.1.6 дээр Лондонгийн металлын биржийн үнэ дээр ингээд 5 хувийн нэмэгдэлтэйгээр гадаад дотоодын зах зээл дээрээс алт худалд алт худалдан авч гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлнэ гэж нэгдүгээрт орсон байгаа. Мөн энэ цаг үед Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас бас санал болгоод Монголбанкт хамтраад гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуйн нэгжид эргэлтийн хөрөнгийн болон урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгох, 5.1.5 дээр шаардлагатай тохиолдолд банкнаас зээл олгоход олгоход тавигдах зохистой харьцааны болон бусад шалгуур үзүүлэлт, зээлийн шаардлага, нөхцөлийг бас

тусгайлан тогтооно гээд ялангуяа алт олборлолтыг нэлээн дэмжсэн зүйл заалтууд нь бас орсон.

Үүн дээр Засгийн газраас Оюу толгойтой яг асуудлыг ярьж байгаа юм байна лээ. Тэгээд Оюу толгойн зүгээс ч гэсэн бид бас нааштай хариу өгч шийдэгдэнэ гэж харж байгаа. Мөн энэ хуулийн 9.1 дээр энэ хууль хүчин хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс өмнөх хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 35.6-д заасныг зөрчсөн этгээдийг энэ хууль үйлчлэх хугацаанд бол аливаа хариуцлагаас чөлөөлнө гэж байгаа. Энэ нь энэ Ашигт малтмалын тухай хуулийн 35.6-д тухайн жилдээ олборлосон алтаа тухайн жилдээ тушаана гэж байдаг. Хэрвээ дараагийн жилд байдаг юм уу, хоёр гурван жил хадгалж байгаад тушаах юм бол энэ зөрчил болдог, хуулийн хариуцлага хүлээлгэдэг. Энийг бол энэ хууль хэрэгжиж байх явцад ямар нэгэн хуулийн хариуцлагаас бол чөлөөлөхөөр байгаа. Тэгэхээр бас иргэд олон нийт, аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ хүнд цаг үед Монголбанк дээр Лондонгийн Хөрөнгийн биржийн бас үнэтэй уялдуулаад та бүхний алтыг бол авахад бэлэн, ямар нэгэн хуулийн хариуцлага санхжүүлт хүлээхгүйгээр энэ хүнд цаг үед бас гадаад валютынхаа албан нөөцийг нэмэгдүүлэхэд та бүхэн маань идэвх чармайлттай оролцооч ээ гэж бас уриалж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Энэ НӨАТ-ын татвараас хөнгөлж болохоор л байгаа юм даа. Гол нэр төрлийн зарим бараа бүтээгдэхүүний үнийн өсөл хомстлоос сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Маргааш эцэслэн батлах болно. Энийг зарлаж байна. Хууль эцэслэн батлах, тав дахь өдрийн 10 цагаас хууль эцэслэн батална гэсэн дэгийн заалттай. Тусдаа зааж болно. Тэгэхээр 39-өөс дээш гишүүнээр батлах учраас маргааш 10 цагаас хууль эцэслэн батлах санал хураалттай гэдгийг гишүүд анхаарах хүсье.